



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 1/389

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх эрхийг хүчингүй болгож,  
нийтийн эзэмшилд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөвсгөл геологи" ХК (РД:2034441)-аас ирүүлсэн хүсэлтийг дагуу Мөрөн сумын 1 дүгээр баг (Гандан хороолол 203-5 байр)-т байршилтай 2690м<sup>2</sup> үйлчилгээтэй орон сууцны зориулалттай 6712017705 нэгж талбарын дугаар бүхий газрын газар эзэмших эрхийг хүчингүй болгож, нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан "Хөвсгөл геологи" ХК (РД:2034441)-ны газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзүл) нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдеж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

